

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ДЭРГЭДЭХ ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№

2022 оны 03 сарын 28

Налайх дүүрэг

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2022 оны 03 сарын 28-ны өдрийн 11:30 цагт эхлэж, 12:00 минутад дуусгав.

Хуралд: Зөвлөлийн дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	Э.Энгүүн
Гишүүд:	Г.Ганцэцэг
	Н.Гантулга
Нярав	Э.Ундармаа нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явагдахтай холбогдуулан бэлтгэл ажил хангах, урьдчилсан тооллого явуулах

СОНССОН НЬ: Н.Пүрэвсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллоготой холбогдуулан тооллогын бэлтгэл ажил хангах ажлын хэсэг томилогдон ажиллаж байгаа. Сая үндсэн хөрөнгийн тооллогыг явуулж дууслаа.

Үндсэн хөрөнгөнөөс дутсан эд зүйл байхгүй, барилга байгууламж болон автомашины хувийн хэргийг бүрэн хөтөлсөн, ажилтнуудын эд хөрөнгийн картыг жилд 2 удаа шинэчлэн баталгаажуулдаг, агуулахын эмх цэгц сайтай, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг тогтмол хийдэг зэрэг давуу талуудтай байлаа.

Мөн хэд хэдэн зөрчил гарсан байна. Үүнд:

- 2021 оны 07 сард гэрчилгээ нь гарсан Багахангай дүүрэг дэх 50 га газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй,

- Зөөврийн компьютер - 2 ширхэг, принтер – 1 ширхэг тус тус ажлын байран дээр байхгүй,

- Тоног төхөөрөмжөөс техникийн үзүүлэлт зөрүүтэй 1 зурагт, 1 принтер, 1 компьютер, 1 утасны аппарат байна.

- Тавилга, эд хогшлоос ашиглагчийн нэр зөрүүтэй, хөрөнгийн бүртгэлийн дугаарыг наагаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Н.Ганцэцэг: 2021 онд 130 га болон 60 га газрыг Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүсэлт явуулан бүртгүүлсэн. 50 га газрыг бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байгаа тул үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байгаа. Хариу нь ирмэгц бүртгэнэ.

Н.Гантулга: Техникийн үзүүлэлт зөрүүтэй байгаа тоног төхөөрөмжүүдийг бүртгэл дээрээ засварлах боломж байдаггүй юм уу? Хариуцсан хүн нь үүнийг улсын үзлэг, тооллогоос өмнө засварласан байх хэрэгтэй байна. Жишээ нь, Samsung-ийн принтерийг Dell гээд бүртгэчихсэн байгаа харагдаад байна.

Н.Пүрэвсүрэн: Энэ бүртгэлийнхээ асуудлыг яаралтай засварлах үүргийг нягтлан, нярав хоёрт өгье. Мөн цаашид тооллого хийлгэхдээ нярав бүх эд хөрөнгөө бүрэн байлгаж, тоолуулахад бэлдсэн баймаар байна. Ажлын байран дээр байхгүй байгаа 2 зөөврийн компьютер, 1 принтер хаана байгаа вэ, яагаад байхгүй байна вэ?


Э.Ундармаа: 1 зөөврийн компьютерийг засварт өгсөн. Нягтлан Г.Ганцэцэг жирэмсний амралтаа аван, гэрээр ажиллаж байгаатай холбогдуулан 1 компьютер, 1 принтерийг авч явсан.

Э.Энгүүн: Мөн автомашины албан татварын болон жолоочийн зөрчлийн торгуулийн төлбөрийг барагдуулсан байх шаардлагатай байгаа. Үүнийг нягтлан, нярав 2 анхаараарай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Нягтлан Г.Ганцэцэг, Нярав Э.Ундармаа нарт доорх гурван чиглэлийн үүрэг даалгаврыг өгөв. Үүнд:

1. Багахангай дүүрэгт байрлах Паркийн эзэмшлийн 50 га газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх
2. Техникийн үзүүлэлт зөрүүтэй эд хөрөнгийн бүртгэлийг засварлаж, бодитоор оруулах, бүртгэлийн дугаар наагаагүй эд хөрөнгөд дугаар наах
3. Автомашины торгуулийн төлбөрийг барагдуулах

ХЯНАСАН:
КОМИССЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ПҮРЭВСҮРЭН
Э.ЭНГҮҮН

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТАЙЛАН

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1, 70.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн 2021 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/15 тоот тушаалын дагуу тооллогын комиссыг байгуулж, даргаар Хуулийн мэргэжилтэн Б.Ариунбилэг, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Х.Бямбаа, Захиргааны ажилтан Д.Номин-Эрдэнэ, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн О.Чулуун-эрдэнэ, Маркетинг ОНХХ хариуцсан мэргэжилтэн Э.Энгүүн нарын бүрэлдэхүүнтэйгээр томилогдож 100 хувийн ирцтэйгээр байгууллагын үндсэн хөрөнгө, хангамжийн материалд тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хийлээ.

Тооллогоор нийт:

- Машин тоног төхөөрөмжийн дансны 28 нэр төрлийн 46,010,000 төгрөгийн хөрөнгө
- Тээврийн хэрэгслийн дансны 1 ширхэг 21,280,000 төгрөгийн хөрөнгө
- Тавилга, эд ахуйн хогшил дансны 52 нэр төрлийн 30,991,100 төгрөгийн хөрөнгө
- Бусад үндсэн хөрөнгө дансны 1,276,790 төгрөгийн хөрөнгө
- Барилга байгууламж дансны 725,673,378 төгрөгийн хөрөнгө
- Бусад биет бус хөрөнгө дансны 57,385,021,500 төгрөгийн хөрөнгө
- Программ хангамж дансны 3,870,000 төгрөгийн хөрөнгө

Нийт 58,214,122,768 төгрөгийн үндсэн хөрөнгө

- Сэлбэг хэрэгсэл 0 төгрөг
- Түлш шатахуун тослох материал 2,527,460 төгрөг
- Бичиг хэргийн материал дансны 40 нэр төрлийн 1,631,380.0 төгрөг
- Аж ахуйн материал дансны 15 нэр төрлийн 3,080,200 төгрөг
- Дуусаагүй үйлдвэрлэл дансны /Барилгын зураг/ 13,000,000 төгрөг

Нийт 20,239,040 төгрөгийн бараа материал тоологдлоо.

Үндсэн хөрөнгө, бараа материалын чанар, үзүүлэлт, хүчин чадал, эд хариуцагч бүрээр тоолж бүртгэн баталгаажуулав.

Архивт байнга хадгалах, түр хадгалах, 70 жил хадгалах болон тусгай төрлийн баримтуудад хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын хүрээнд тооллого хийж тоолсон болно.

1. Байнга хадгалах баримт 2014-2020 оны нийт 294 боть
2. Түр хадгалах баримт 2014-2020 оны нийт 237 боть
3. 70 жил хадгалах баримт 2014-2020 оны нийт 33 боть
4. Зураг, төсөл хадгалах баримт 2014-2019 оны нийт 19
5. Гэрэл зургийн цомгийн бүртгэл 2014-2020 оны нийт 233 зураг
6. Цахим гэрэл зургийн 2014-2020 оны 9cd/2951 зураг
7. Захирамжлалын цахим баримтын бүртгэл 2014-2020 оны 14cd

8. Цахим ажлын файлын бүртгэл 2014-2019 оны 20 dvd
9. Цахим зураг төслийн 2014-2020 оны 4cd
10. Видео дүрс бичлэг 2014-2020 оны 2cd
11. Нөөц хувь 2014-2020 оны 25 cd-ийг тус тус тоолсон.

Хэвлэмэл хуудасны зарцуулалт тушаалын бланк 146 ширхэг, албан бичгийн А4 бланк 138 ширхэг, албан бичгийн А5 бланк 164 ширхэг нийт 448 ширхэг хэвлэмэл хуудасны үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын чанар үзүүлэлт, хүчин чадал, эд хариуцагч бүрээр тоолж бүртгэв.

Тооллогоор элэгдлийн хугацаа дууссан:

- Машин тоног төхөөрөмж- 19 нэр төрөл үүнээс 9 муу ангилалтай
- Тавилга, аж ахуйн эд хогшил- 20 нэр төрөл үүнээс 11 муу ангилалтай
- Тээврийн хэрэгсэл- маш муу элэгдлийн хугацаа дуусаад удсан
- Бусад үндсэн хөрөнгө- 4 үүнээс 0 муу ангилалтай
- Программ хангамж- 3, үүнээс 0 нь муу ангилалтай тус тус тоологдсон.

Элэгдлийн хугацаа дууссан эвдэрхий дахин ашиглах боломжгүй эдгээр хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж, ашиглах боломжгүй эд хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт тайланг хүргүүлж устгалд оруулах саналтай байна. Үүнд:


№	Үндсэн хөрөнгийн нэр	Хөрөнгийн дугаар	Тоо, ширхэг	Элэгдлийн хугацаа, чанар
1	Суудлын автомашин	00000243	1	Хугацаа дууссан, муу
2	Dell зөөврийн компьютер	00000036	1	Хугацаа дууссан, муу
3	HP 1132 принтер	00000037	1	Хугацаа дууссан, муу
4	Dell 2020 panel компьютер	00000184	1	Хугацаа дууссан, муу
5	Принтер Epson 1390	00000186	1	Хугацаа дууссан, муу
6	Samsung SCX 3405 принтер	00000187	1	Хугацаа дууссан, муу
7	Samsung 1640 принтер	00000193	1	Хугацаа дууссан, муу
8	Өсгөгч 1	00000231	1	Хугацаа дууссан, муу
9	Зөөврийн компьютер Асер	00000776	1	Хугацаа дууссан, муу
10	Зөөврийн компьютер HP I5	00000912	1	Хугацаа дууссан, муу
11	Сандал	00000040	3	Хугацаа дууссан, муу
12	Ханын шкаф	00000199	1	Хугацаа дууссан, муу
13	Шкаф	00000039	1	Хугацаа дууссан, муу
14	Сандал	00000201	6	Хугацаа дууссан, муу
15	Буйдан /урт/	00000204	2	Хугацаа дууссан, муу
16	Сандал /дарга/	00000205	1	Хугацаа дууссан, муу

17	Ком ширээ	00000206	1	Хугацаа дууссан, муу
18	Теннисний ширээ	00000215	1	Хугацаа дууссан, муу
19	Хурлын ширээ	00000200	1	Хугацаа дууссан, муу
20	Ширээ	00000038	1	Хугацаа дууссан, муу
21	Сандал	00000201	5	Хугацаа дууссан, муу
22	Зөөлөвчтэй хар сандал	00000217	1	Хугацаа дууссан, муу
23	Тумбочка шкаф	00000216	1	Хугацаа дууссан, муу
24	Проёкторын самбарын хөл тогтоогч	00000214	1	Хугацаа дууссан, муу


Дээрх хөрөнгөнүүд нь 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 200 дугаар тогтоолоор Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс манай паркт шилжиж ирсэн хөрөнгө юм.

Үндсэн хөрөнгө, хангамжийн материалд дутсан, зөрсөн, илүү гарсан эд хөрөнгө байхгүй болно. Нярав болон эд хариуцагч бүрийн ашиглаж байгаа хөрөнгийн чанар, хүчин чадлыг асуун фото зурагтай тулган баталгаажуулж, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг баримтжуулан ажилласан. 2021 оны жилийн эцсийн тооллого 12 дугаар сарын 28-ны өдөр дууссан болно.


Тооллогын комиссын дарга:

 /Б.Ариунбилэг/

Тооллогын комиссын гишүүн

 /Х.Бямбаа/

 /Д.Номин-эрдэнэ/

 /О.Чулуун-Эрдэнэ/

 /Э.Энгүүн/